



ДАРХАН-УУЛ АЙМАГ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 09 дугаар сарын 23

Дугаар А/58

Дархан

Ёс зүйн хороо байгуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, Засгийн Газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” Боловсрол Соёл Шинжлэх Ухаан, спортын сайдын “Дүрэм, журам батлах тухай” А/243 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсрол, соёл, урлагийн газрын дэргэд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Дарга: Е.Өсөхбаяр /БСУГ-ын мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга: У.Мөнхцэцэг /НТБТөвийн нийгмийн ажилтан/
Гишүүд: Г.Энхтулга /8-р цэцэрлэгийн эрхлэгч/
Д.Идэрхангай /Од цогцолбор сургуулийн сургалтын менежер/
Б.Энхбат /15-р сургуулийн бага ангийн багш/
Н.Цолмон /16-р сургуулийн МХУЗ-ын багш/
Н.Баасүрэн /11-р цэцэрлэгийн бүлгийн багш/

2. Ёс зүйн хороо нь хууль эрхзүйн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, байгууллага бүрийн ёс зүйн зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, ажлын тайланг улирал бүр тайлагнаж байхыг ёс зүйн хороо /Е.Өсөхбаяр/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

9023046 1517134450